

ИНЕГ-ЫН УДИРДЛАГУУД БОЛОН ИКАО-ЫН USOAP АУДИТАД
БЭЛТГЭХ ЗОХИЦУУЛАХ ТӨВИЙН ДУНД ХИЙГДСЭН УУЛЗАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2009 оны 12 дугаар сарын 1

Оролцсон хүмүүс:

Г.Даваа- газрын дарга
С.Итгэл-ЭЗЗХА-ны ерөнхий менежер
С.Манлай- ЗХНХМХ-ийн дарга
П.Ариунгэрэл –НМХА-ны дарга
Ж.Энхболд – Нисэхийн цаг уурын төвийн дарга
С.Ерөөлт – НААХЗА-ны ҮГХ-ийн дарга
Ж.Цолмон – НААХЗА-ны ААХХ-ийн дарга
Н.Ганболд - НААХЗА-ны НТЧХ-ийн дарга
М.Эрдэнэбатмөнх- НААХЗА-ны НСҮАХХ-ийн дарга
Н.Болдбаатар- ЧХОНБ-ын дарга
Р.Баатархуяг – НХА-ны дарга
Д.Гантөмөр – Сургалтын төвийн захирал
Б.Мөнхжаргал –Аэродромын албаны дарга
Г.Таванжин – НХҮА-ны технологийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Д.Баяртогтох- ТХА-ны Ерөнхий инженер
Н.Батзориг - НБҮМХ-ийн төслийн менежер

ИНЕГ-ын ИКАО-ын аудитад бэлтгэх ажлын хэсэг:

- ажлын хэсгийн ахлагч -Д.Батчулуун
- ажлын хэсгийн гишүүд /П.Пүрэвсүх, Ө.Батсайхан, П.Гантөгс, Д.Хишгээ,

Т.Алтанзул/

Д.Батчулуун:

Өнөөдөр, 1-рт, Бид Солонгостой туршлага судлах талыг түлхүү анхаарч үзэн, тэдэнтэй холбоо тогтоож, дэд зохицуулагч нарын хүрээнд НААХЗА-ын байцаагчдыг KCASA руу явуулж ИКАО-гийн шалгалтанд хэрхэн бэлдсэн талаар судлуулахаар болсон. Солонгосын тал 12 дугаар сарын 21-нээс 23-ны өдрүүдэд хүлээж авах боломжтой гэсний дагуу 21-23-нд хүмүүсээ явуулахаар болоод байна.

2-рт, Бид ОБЕГ-той уулзаж, ойрын хугацаанд хамтарсан семинар зохион байгуулахаар болсон.

3-рт, Протоколын хэмжээнд тайлан гаргасан байгаа. ҮГХ-ийнхний гаргасан график шиг бүгд нэгэн жигд хийе гэж ярьсан. Ажлын чанартай уулзаж энэ асуудлаар дахин ярья. SAAQ-ыг бүх сувгаар явуулсан. Даваа дарга, Итгэл, Ерөөлт, Энхбат гээд нийт дөрөвхөн хүнээс санал ирсэн ба саналыг тусгасан. Бусад санал ирүүлээгүй хүмүүсийг саналгүй гэж үзэж болох юм. SAAQ-ыг явуулахад бэлэн боллоо гэж үзээд ИКАО руу явуулъя гэж бодож байна. SAAQ-д өгсөн саналуудыг танилцуулъя, хамтарч үзээд нэгдсэн ойлголтод хүрье.

Танилцуулгаар, SAAQ-ыг авч хэлэлцээд дараах шийдэлд хүрэв.

- GEN 1.8 - Даваа даргын саналыг хүлээж авав.
- LEG 2.12 - Yes гэж хариулчихаад асуудал гарвал дараа нь маргах нь зүйтэй гэсэн Даваа даргын саналын дагуу Yes гэж хариулахаар тогтов.
- ORG 3.1.11- Даваа даргын саналаар хуучнаар нь хариулахаар тогтов.
- ORG 3.1.15 - Yes гэж хариулахаар саналыг хүлээн авав.
- ORG 3.1.19 – Номын сантай болно гэж үзээд Yes гэж хариулахаар саналыг хүлээн авав.
- ORG 3.1.21 – Даваа даргын саналаар хариултыг хураангуйлав.

- SMP 3.2.2 - НААХЗА-ынхан болон бусад алба хэлтсийн дарга нар эрсдлийг таних, засаж залруулах, урьдчилан сэргийлэх ажиллагаа хийгддэг гэж үзсэн учраас энэ 7 хоногийн 4 дэх өдөр буюу 12 сарын 17-ны дотор эрх зүйн холбогдох заалт, хариултыг ирүүлэхээр тогтов.
- PEL 4.1.32 – НААХЗА-ны ҮГХ-ийн дарга С. Ерөөлт Төлөвлөгөөг гарган 3-н сардаа багтаан явуулахаар шийдвэрлэв.
- AIR 4.4.4 – Зохион бүтээгч, үйлдвэрлэгч улсад байдаг тул манайд шаардлагагүй бөгөөд энэ нь сөрөг үнэлгээ болохгүй.
- AIR 4.4.7 – Саналыг тусгав. НТЧ-ийн хэлтэс дээр хийгддэг гэж үзэв.
- AIR 4.4.18 – Саналыг тусгав. Байцаагчийн зааварт өөрчлөлт оруулах шаардлагатай. Ажлын байрны тодорхойлолтонд оруулах.
- AIR 4.4.29 - Одоогоор бид юу ч зохион бүтээдэггүй, бас үйлдвэрлэдэггүй тул No гэж хариулах.
- AIR 4.4.44 - НТЧХ-ийн дарга Н.Ганболд хариултыг 12 сарын 17-ны дотор ирүүлэхээр тогтов. Тус систем нь ИНЕГ-т хэрэгжсэн тогтсон систем гэж хариултыг өгсөн учраас холбогдох эрх зүйн заалтуудыг ирүүлэх.
- AIR 4.4.45 - Саналыг тусгаад Yes гэж хариулахаар болов. Шинэчлэх дүрмийг анхаарах.
- ENV 4.5.1 – Зохицуулах төвийн гишүүн Ө.Батсайхан Индонезийн 2 дүрмийг ИНД-21-тэй тулган үзэж, зохих өөрчлөлтүүдийг оруулахаар тогтов.
- DG 4.6.2 – No хариулт хэвээрээ байхаар тогтов.
- IFR-4.7.1 - ААХ-ийн дарга Ж.Цолмон энэ асуудлыг анхаарч, холбогдох заалтыг Хэлтсийн заавартаа тусгах, Procedure Design-ний сургалтанд хамрагдсан хүнийг хэлтэстээ нэмж авахаар тогтов.
- ATS-5.1.3 - Yes гэж хариулахаар тогтов.
- ATS-5.1.11 - Даваа дарга чиглэл хариуцсан хүнд үүрэг даалгавар өгч, баталгаажуулах.
- ATS-5.1.17 - Yes гэж хариулахаар тогтов. Веб-ийг зааж өгөх.
- ATS-5.1.19 - Даваа даргын өмнө өгсөн саналыг тусгав.
- CNS-5.4.5 - Зохицуулах төвийн гишүүн п.гантөгс холбогдох материалыг даваа даргад гаргаж өгөхөөр болов.
- CNS-5.5.7 - НХҮА-ны дарга Р.Баатархуяг 12 сарын 17-ны дотор энэ талаар Батхаанаас тодруулж асуун, хариуг мэдэгдэхээр болов.
- AGA 6.19 - Yes гэж хариулах, НААХЗА-ны ААХ-ийн дарга Ж.Цолмонд үйл ажиллагааны Заавартаа ийм мэдээлэл оруулдаг гэдэг өгүүлбэр оруулахыг үүрэг болгов.
- AGA 6.23 - Шинэ нисэх буудал барих төлөвлөгөө нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт байгааг зааж өгөх.
- AGA 6.34 - Yes гэж хариулахаар тогтов. Өнгөрсөн онуудад гарсан тохиолдлуудын мэдээллийн бүртгэлийг нэгтгэн гаргах.

Д.Батчулуун: 4-рт, LEG болон ORG-ийн “No” хариултын талаар танилцуулгыг асуулга бүрээр хийв.

Шийдвэрлэсэн нь: Дараагийн 2 дахь өдрийн уулзалтаар дэд зохицуулагч нар мэдээлэл хийх ба СЕ-ээрээ танилцуулга бэлдэж ирэхээр тогтов.

Тэмдэглэл хөтөлсөн: Т.Алтанзул